

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн	6
2.8.1. Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	6
2.8.2 Авлага.....	6
2.8.3 Бараа материал	7
2.8.4. Үндсэн хөрөнгө.....	7
2.8.5. Өр төлбөр.....	9
2.8.6 Засгийн газрын хувь оролцоо.....	9
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	10
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	11
2.12. Шилэн дансны мэдээлэл	11
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3. Менежментийн захидал.....	12
3.1. Зардлын данстай холбоотой асуудал.....	12
3.2. Зардлын данстай холбоотой асуудал.....	12
3.3. Харьяа хэлтэс болон дотоод хяналттай холбоотой асуудал.....	13
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	14
4.2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	15
4.3. Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	20
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН
ХОРООНЫ ДАРГА А.АРИУНЗАЯА
ТАНАА

2020.04.24 № 1327
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

A red rectangular official stamp is placed over a handwritten signature. The signature is in black ink and appears to read 'Д.ЗАНДАНБАТ'. The stamp contains a central emblem, likely the coat of arms of Mongolia, and some text in Mongolian script, though it is partially obscured by the signature.

Д.ЗАНДАНБАТ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус хорооны дарга А.Ариунзаяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, дотоод хяналтыг сайжруулахтай холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 5-аас 2020 оны 4 дүгээр сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор Д.Цэгмиддорж хариуцаж гүйцэтгэв.

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 4 дүгээр сарын 02-ны өдрийн 03/249 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе

шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Үндэсний статистикийн хороо нь эрхэм зорилгоо "Статистикийн мэдээллийн чанарыг сайжруулах, хэрэглээ ашиглалтыг нэмэгдүүлэх, орон нутгийн статистикийн нэгжийн чадавхыг бэхжүүлэх" гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгыг биелүүлэхдээ статистикийн салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулах, статистикийн ерөнхий үйл ажиллагааны стандарт нэвтрүүлэх бэлтгэлийг хангах, үндэсний тооцооны системийн ашиглалтыг нэмэгдүүлэх, олон жилийн динамик мэдээлэлд үндэслэн шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх, статистикийн мэдээллийн чанар, шуурхай байдлыг сайжруулах, төрийн байгууллагуудын статистикийн мэдээллийн сангийн уялдааг хангаж, албан ёсны статистикийн хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэх, тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг бий болгох хөгжлийн байгууллагуудын дэмжлэг, туслалцааг статистикийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд чиглүүлэх гэж үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Үндэсний статистикийн хорооны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Үндэсний статистикийн хорооны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Үндэсний статистикийн хорооны Дотоод аудит мониторингийн хэлтэс 2019 онд харьяа орон нутаг дахь 20 газрын санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 209 зөвлөмж өгсөн байна. Үндэсний аудитын газраас Үндэсний Статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, акт, албан шаардлагын биелэлтийг аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтсүүдээс авч нэгтгэн 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 02/652 дугаартай албан бичгээр ирүүлсэн бөгөөд, зөвлөмжийн хэрэгжилт 99.8 хувьтай байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Үндэсний статистикийн хорооны даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 14 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 14 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд Сонгосон суурь үзүүлэлт болох нийт зардал 11,423.2 сая төгрөгийн 2 хувиар тооцож, материаллаг байдлын түвшнийг урьдчилсан байдлаар 228.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 12,914.5 сая төгрөгийн 2 хувиар тооцож 258.3 сая төгрөгөөр тогтоолоо.

2.8. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

2.8.1. Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 0.9 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 18.9 сая төгрөг болж, 18.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	0.9	18.9	18.0
Дүн	0.9	18.9	18.0
Төсөвт байгууллага	0.9	18.9	18.0
Дүн	0.9	18.9	18.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны А/78 тоот “Ахмадын сан байгуулах тухай” тушаалын дагуу цалингийн сангийн 1 хувьтай тэнцэх хэмжээгээр ахмадын сангийн дансанд 18.9 сая төгрөгийн үлдэгдэл байна. Үүнээс Үндэсний статистикийн хорооны аппаратын ахмадын сангийн үлдэгдэл 18.4 сая төгрөг, Дундговь аймгийн статистикийн хэлтсийн ахмадын сангийн үлдэгдэл 0.5 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

- Нийслэлийн статистикийн газар нь анхан шатны баримтын бүрдэлгүй 40.1 сая төгрөгийн гүйлгээ хийсэн,
- Үндэсний статистикийн хороо нь оны эцэст ахмадын сан байгуулж цалингийн зардлын хэмнэлтээс 18.3 сая төгрөгийг шилжүүлсэн, ахмадын сан байгуулахад шаардагдах хөрөнгийг төсөвт тусгаагүй;

2.8.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 151.6 сая төгрөг болж, 60.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.6	2.0	1.4
Татаас, санхүүжилтийн авлага	90.5	149.1	58.6
Бусад авлага	0.2	0.5	0.3
Дүн	91.3	151.6	60.3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 97.8 хувь буюу 148.2 сая төгрөг нь нэмэлт санхүүжилтийн дансны татаас санхүүжилтийн авлага эзэлж байна. Нэмэлт санхүүжилтийн дансны 148.2 сая төгрөг, урсгал

дансны санхүүжилтийн авлага 0.9 сая төгрөгийн авлагыг Сангийн яамны Төрийн сангийн газартай тооцоо нийлж баталгаажуулсан байна.

2.8.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 211.2 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 272.8 сая төгрөг болж, 61.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	13.55	34.2	20.7
Бэлэн бүтээгдэхүүн	1.6	5.3	3.7
Бичиг хэргийн материал	68.1	68.0	-0.1
Аж ахуйн материал	97.2	102.3	5.1
Сэлбэг хэрэгсэл	1.5	6.6	5.1
Түлш шатах тослох материал	2.3	18.2	15.9
Хүнсний материал	0.03	0.06	0.03
Бусад хангамжийн материал	26.9	38.2	11.3
Дүн	211.2	272.8	61.6
Төсөвт байгууллага	211.2	272.8	61.6
Дүн	211.2	272.8	61.6

Эх сурвалж Үндэсний статистикийн хорооны 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 61.6 сая төгрөгөөр өссөн шалтгаан нь 10 жил тутам явагддаг Хүн ам, орон сууцны ээлжит тооллого, 5 жил тутам явагддаг ХАА-н завсрын тооллого явагдахтай холбогдуулан 2020 оны тооллогод шаардагдах бараа, материалыг нөөцөлсөнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Говь-Алтай аймгийн статистикийн хэлтэс хичээл практикийн зардлыг тооцоход нярвын тайланд орлогоор бүртгээгүй шууд зардлаар тайлагнасан, хөрөнгийн тооллогыг НББ-тэй тулгахад бараа материалыг дутуу тоолсон нийт 1.0 сая төгрөг, тээвэр шатахууны зарцуулалтад худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй 29.1 сая төгрөг,
- Өвөрхангай аймгийн статистикийн хэлтэс “Идэрийн ундраа” ХХК-аас шууд гэрээгээр 23.3 сая төгрөгийн шатахуун худалдан авсан,
- Дорнод аймгийн статистикийн хэлтэс тайлант хугацаанд 27.8 сая төгрөгийн худалдан авалтын Е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй;

2.8.4. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,782.3 сая төгрөг байсан бол 91.7 сая төгрөгөөр нэмэгдэж эцсийн үлдэгдэл 5,874.0 сая төгрөг болжээ.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	10.8	10.8	0
Авто тээврийн хэрэгсэл	483.1	507.9	24.8
Машин тоног төхөөрөмж /компьютер/	4,041.1	4,072.5	31.4
Тавилга, аж ахуйн эд хогшил	565.5	576.6	11.1
Номын фонд	0.1	0.1	0
Бусад үндсэн хөрөнгө	5.1	4.5	-0.6
Програм хангамж	675.8	700.8	25.0
Бусад биет бус хөрөнгө	0.8	0.8	0
Дүн	5,782.3	5,874.0	91.7
Төсөвт байгууллага	5,782.3	5,874.0	91.7
Дүн	5,782.3	5,874.0	91.7

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 129.2 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 35.2 сая, аймаг нийслэлийн засаг даргын нөөц

хөрөнгөнөөс шийдвэрлүүлсэн 40.2 сая, хандив тусламжаар үнэ төлбөргүй авсан 164.5 сая төгрөгийн буюу нийт 369.1 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө балансаас баланст шилжүүлсэн 0.4 сая, акталсан 276.9 сая төгрөгийн хөрөнгийн дүнгээр буурсан байна.

Тайлант онд “Хүн ам, орон сууцны тооллого” явагдахтай холбоотойгоор төсвийн хөрөнгөөр Үндэсний статистикийн хороо 104.2 сая, Архангай аймгийн статистикийн хэлтэс 2.0 сая, Говь-Алтай аймгийн статистикийн хэлтэс 2.9 сая, Увс аймгийн статистикийн хэлтэс 9.6 сая, Хэнтий аймгийн статистикийн хэлтэс 2.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг тус тус худалдан авчээ.

Орхон аймгийн Статистикийн хэлтэс Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 24.8 сая төгрөгийн үнэтэй Toyota Vanguard авто машин худалдан авсан байна.

Үндэсний статистикийн хороо 104.2 сая төгрөг, Архангай 2.0 сая төгрөг, Говь-Алтай 2.9 сая төгрөг, Увс 9.7 сая төгрөг, Хэнтий 2.6 сая төгрөг, зэрэг аймгуудын статистикийн хэлтсүүд нийт 121.4 төгрөгийн машин тоног төхөөрөмжийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан байна.

Үндэсний статистикийн хороо 157.5 сая төгрөг, Нийслэлийн Статистикийн хэлтэс 5.5 сая төгрөг, Өвөрхангай аймгийн Статистикийн хэлтэс 1.8 сая төгрөг, Дорноговь аймгийн Статистикийн хэлтэс 3.7 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Статистикийн хэлтэс 5.5 сая төгрөг, нийт 174.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хандиваар авч бүртгэжээ.

Нийслэлийн Статистикийн хэлтэс 0.8 сая төгрөг, Орхон аймгийн Статистикийн хэлтэс 5.1 сая төгрөг, нийт 5.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлэн авсан байна.

Мөн анхны үнээ элэгдлээрээ нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан, эвдэрч гэмтсэн цаашид ашиглах боломжгүй хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 2/2232 тоот тогтоолоор нийт 249.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, данс бүртгэлээс хассан. /Архангай 5.2 сая төгрөг, Дорноговь 4.5 сая төгрөг, Дархан-Уул 14.7 сая төгрөг, Төв 10.1 сая төгрөг, Үндэсний статистикийн хороо 214.9 сая төгрөг/

Орон нутгийн өмчийн газрын шийдвэрээр Баянхонгор 19.1 сая төгрөг, Булган 2.9 сая төгрөг, Орхон 5.6 сая төгрөг, нийт 27.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, данс бүртгэлээс хассан байна.

Өвөрхангай аймгийн статистикийн хэлтэс 1.2 сая төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авсан, Үндэсний статистикийн хороо 7.0 сая төгрөг, Өвөрхангай 2.7 сая төгрөг, Сэлэнгэ 2.7 сая төгрөг, нийт 12.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хандиваар, Орхон 4.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлэн авч бүртгэсэн байна.

Холбогдох газрын шийдвэрээр 6.9 сая төгрөгийн тавилга эд хогшил акталж устгасан байна.

Программ хангамжийн хувьд “Хүн ам, орон сууцны 2020 ээлжит тооллого”-ын бэлтгэл ажлын хүрээнд хүн ам, өрхийн мэдээллийн санг өргөтгөн шинэчлэхээр 25.0 сая төгрөгийн программ худалдан авсан байна.

Бусад үндсэн хөрөнгийн хувьд Баянхонгор 0.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, Нийслэл 0.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бараа материалын данс руу шилжүүлэн бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт: Говьсүмбэр аймгийн статистикийн хэлтэс үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй цаашид ашиглах боломжгүй 21 нэр төрлийн 19.8 сая төгрөгийн хөрөнгөнд ашиглалтын хугацаа болон үнэлгээ тогтоогоогүй;

2.8.5. Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 0.5 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 5.0 сая төгрөг болж, 4.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	0.5	5.0	4.5
Өглөг	0.5	5.0	4.5
Бусад өглөг	0.5	5.0	4.5
Байгууллагад төлөх өглөг	0.4	2.8	2.2
Хувь хүмүүст төлөх өглөг	0.1	2.2	2.1
Нийт дүн	0.56	5.0	4.5
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	0.5	5.0	4.5
ДҮН			

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Байгууллагын даргын тушаалаар олгогдох нэг удаагийн буцалтгүй тусламжийн 1.4 сая төгрөг, хувь хүмүүст өгөх бусад өглөг 0.8 сая төгрөг, ХХОАТ-ын 1.9 сая, байгууллагад бусад төлөх 0.9 сая, нийт 5.0 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

2.8.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,746.4 сая төгрөг болж, 6.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Төсөвт байгууллага	1752.7	1746.4	-6.3
Дүн	1752.7	1746.4	-6.3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Орон нутгийн өмчийн газрын шийдвэрээр үндсэн хөрөнгө акталснаас Засгийн газрын хувь оролцоо буурсан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 10,214.8 сая төгрөгийн урсгал зардлын төсөв батлагджээ.

Нийт зардлын 10,214.8 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 10,190.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгож 24.1 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан бол туслах үйл ажиллагааны орлогоос 7.4 сая төгрөг, нийт 10,217.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж 9,966.1 сая төгрөгийг зарцуулж 232.0 сая төгрөгийг улсын төсөвт буцааж төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 9,966.1 сая төгрөг буюу 97.6 хувьтай, 248.7 сая төгрөгийг дутуу зарцуулсан байна.

Батлагдсан төсвөөс эдийн засгийн ангиллаар материаллаг дүнтэй дутуу зарцуулсан дараах зардлууд байна. Үүнд:

- Сүхбаатар аймгийн статистикийн хэлтсийн 2 мэргэжилтэн, Төв болон Говьсүмбэр аймгийн статистикийн хэлтсийн тус бүр 1 нэг мэргэжилтэн жирэмсэн амаржсаны чөлөөтэй байх хугацаанд орон тоо дутуу ажиллаж цалингийн зардлыг 18.9 сая төгрөгөөр дутуу зарцуулсан;
- Байшин орон сууцны 2019 оны завсрын тооллогын зардлын төсөв дээр 140.0 сая төгрөгийн эд хогшил худалдан авах зардал батлагдсан бөгөөд үүнээс 108.1 сая төгрөгийн худалдан авалт хийж 31.9 сая төгрөгийн тендерийн хэмнэлт үүссэн;
- Тооллого судалгааны зардал 153.9 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь Судалгааны хяналт хийхдээ чиглэл болон судалгааны хүрээгээр нэгтгэн явуулсан тул төсвөөс мөнгө хэмнэх бололцоо бүрдүүлж 24.0 сая төгрөгийн санхүүжилт аваагүй, 76.6 сая төгрөг судалгааны зардлаас 53.0 сая төгрөг холбооны сувгийн түрээсийн төлбөрөөс хэмнэн буцаан төвлөрүүлсэн;
- Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 19.8 сая төгрөгөөр дутуу зарцуулжээ. Энэ нь Үндэсний статистикийн хорооны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний Статистикийн мэдээллийн чанар, шуурхай байдлыг сайжруулах, төрийн байгууллагуудын статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн уялдааг хангаж, албан ёсны статистикийн хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэх зорилт болон “Төрийн албаны тухай” шинэчилсэн хуулийг дагалдан гарах журмын хэрэгжилтийн хүрээнд Дорноговь, Өмнөговь, Дундговь, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Архангай, Увс, Баян-Өлгий, Ховд (17) аймгуудын төрийн болон аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл, сумдын статистикийн асуудал хариуцсан 3040 орчим мэргэжилтнийг хамруулсан сургалтыг 2019 оны 6, 9 дүгээр саруудад зохион байгуулахдаа Тогтвортой хөгжлийн зорилтын Ухаалаг засаглал төслөөс санхүүжүүлснээс шалтгаалж төлөвлөгөөнөөс дутуу зарцуулжээ.

Нэмэлт төсөв: Хандив тусламжаар 58 байгууллага, гадаад төсөл хөтөлбөрөөс 1,208.7 сая төгрөг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын нөөц хөрөнгөнөөс 1,131.1 сая, дээд шатны төсвийн захирагчаас 3,462.3 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 222.4 сая, нийт 6,024.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үйл ажиллагааны зардалд 5,871.1 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 153.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж үүнээс 148.2 сая төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэн тооцоо нийлж баталгаажуулсан байна.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 23 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагад итгэл үзүүлж, 15 байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт өгч, 2 байгууллагыг түүвэрт хамруулсан байна.

Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 280.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 92.0 сая төгрөгийн алдааг залруулж, 0.7 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 65.1 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 122.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 13 зөвлөмж өглөө.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын явцад түүвэрт хамрагдсан байгууллагын цалингийн зардалд давтан тооцоолол хийж, цагийн бүртгэлийг мөшгин шалгаж тулган баталгаажуулж амжаагүй болно.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Үндэсний статистикийн хороо нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу 135 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн 3.8 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоосныг барагдуулсан, 110.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

Нийт 17 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБООС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНБООС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд Менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Үндэсний статистикийн хорооны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Оны эцэст ахмадын сан байгуулж цалингийн зардлын хэмнэлтээс 18.3 сая төгрөгийг шилжүүлсэн нь Монгол улсын Засгийн газрын 2017 оны “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам” 197 тоот тогтоолын 1.3-т “Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана” гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, Төсвийн тухай хууль, холбогдох заавар журмыг мөрдөж ажиллаагүй байх;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Ахмадын сангийн хөрөнгийг тухай жилийн төсөвт суулган батлуулж, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 197 тоот тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам” холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2. Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Такт энтертайнмент ХХК-аас худалдан авсан 2.5 сая төгрөгийн бараа материалыг шууд зардлаар бүртгэсэн, Ай Ти Зон ХХК-тай хийсэн гэрээний үүргийг биелүүлж ажиллаагүй, гэрээ дүгнэсэн актад тодорхой тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.2-т заасантай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Холбогдох хууль, журам заавар хэрэгжүүлээгүй байх санхүүгийн тайлангийн тоо мэдээ буруу илэрхийлэгдэх;

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасныг мөрдөж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3. Харьяа хэлтэс болон дотоод хяналттай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 188.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна. Төсвийн тухай болон бусад хууль, холбогдох журам, зааврыг мөрдөж ажиллаагүйгээс 0.7 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 65.1 сая төгрөгийн 4 албан шаардлага, 122.7 сая төгрөгийн 13 зөвлөмж өгсөн.

3.3.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлангийн тоо мэдээ буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль, журам зааврыг мөрдөж ажиллаагүй байх;

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Хяналт шинжилгээ, мониторингийн хэлтэс харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	303,357.9	443,317.9
МӨНГӨН ХӨРӨНГӨ	892.8	18,862.7
АВЛАГА	91,285.2	151,601.2
БАРАА МАТЕРИАЛ	211,179.9	272,854.1
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,449,904.2	1,308,121.4
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,449,904.2	1,308,121.4
Биет хөрөнгө	1,289,052.5	1,191,225.9
Биет бус хөрөнгө	160,851.6	116,895.5
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,753,262.0	1,751,439.3
НИЙТ ӨР ТӨЛБӨР	559.2	5,035.0
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	559.2	5,035.0
Өглөг	559.2	5,035.0
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,752,702.8	1,746,404.2
Засгийн газрын хувь оролцоо	1,752,702.8	1,746,404.2
Хуримтлагдсан үр дүн	1,746,858.6	1,740,560.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,844.2	5,844.2
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,753,262.0	1,751,439.3

4.2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	11,197,535.4	12,908,221.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	489,723.8	245,657.8
Нийтлэг татварын бус орлого	489,723.8	245,657.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,707,811.6	12,662,563.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	11,422,441.0	12,914,472.9
УРСГАЛ ЗАРДАЛ	11,422,441.0	12,914,472.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,643,125.2	12,473,891.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,718,477.1	4,436,433.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	437,121.0	534,140.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	900.0
Хангамж, бараа материалын зардал	491,925.9	675,811.0
Нормативт зардал	444.0	5,446.0
Эд хогшил, урсгал засварын зардал	40,671.6	66,368.5
Томилолт, зочны зардал	341,065.4	314,494.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,870,410.7	5,521,200.1
Бараа үйлчилгээний бусад зардал	743,009.5	919,098.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	779,315.8	440,581.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-224,905.6	-6,251.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	724.8	46.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-225,630.4	-6,298.6

4.3. Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	10,762,540.3	12,779,971.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,174.4	27,050.4
Нийтлэг татварын бус орлого	8,174.4	27,050.4
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,754,365.8	12,752,921.4
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,819,510.1	12,614,444.1
УРСГАЛ ЗАРДАЛ	10,819,510.1	12,614,444.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,949,682.5	12,025,107.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,721,708.6	4,426,155.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	436,973.3	539,275.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.0	900.0
Хангамж, бараа материалын зардал	463,591.6	634,325.6
Нормативт зардал	444.0	4,846.0
Эд хогшил, урсгал засварын зардал	56,054.2	89,025.0
Томилолт, зочны зардал	341,121.0	314,605.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,753,537.8	5,603,989.3
Бараа үйлчилгээний бусад зардал	176,251.9	411,984.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	869,827.6	589,336.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-56,969.9	165,527.7
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	9,369.6	147,557.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,369.6	147,557.9
Дотоод эх үүсвэрээр	9,369.6	147,557.9
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-9,369.6	-147,557.9
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-66,339.5	17,969.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	67,232.2	892.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	892.8	18,862.7

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,008,874.6	0.0	2,008,874.6
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-36,385.6	0.0	-36,385.6
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,972,489.0	0.0	1,972,489.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	5,844.2	0.0	5,844.2
Тайлант үеийн үр дүн	-225,630.4	0.0	-225,630.4
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,752,702.8	0.0	1,752,702.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,752,702.8	0.0	1,752,702.8
Тайлант үеийн үр дүн	-6,298.6	0.0	-6,298.6
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,746,404.2	0.0	1,746,404.2

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,214,759.7	9,966,091.8	248,667.9	97.6
УРСГАЛ ЗАРДАЛ	10,214,759.7	9,966,091.8	248,667.9	97.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,037,371.6	9,789,123.7	248,247.9	97.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,005,510.0	3,986,575.8	18,934.2	99.5
Үндсэн цалин	2,970,166.9	2,981,121.6	-10,954.7	100.4
Нэмэгдэл	824,301.5	796,633.6	27,667.9	96.6
Унаа хоолны хөнгөлөлт	211,041.6	208,820.6	2,221.0	98.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	501,105.0	498,895.9	2,209.1	99.6
Тэтгэврийн даатгал	340,859.7	356,071.1	-15,211.4	104.5
Тэтгэмжийн даатгал	40,061.2	35,815.7	4,245.5	89.4
ҮОМШӨ-ний даатгал	32,049.2	28,159.2	3,890.0	87.9
Ажилгүйдлийн даатгал	8,012.2	7,376.0	636.2	92.1
Эрүүл мэндийн даатгал	80,122.7	71,473.9	8,648.8	89.2
Хангамж, бараа материалын зардал	159,591.4	156,339.1	3,252.3	98.0
Бичиг хэрэг	36,559.8	38,778.4	-2,218.6	106.1
Тээвэр, шатахуун	45,645.4	43,902.0	1,743.4	96.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	48,762.1	45,364.6	3,397.5	93.0
Ном, хэвлэл	16,526.2	16,517.7	8.5	99.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,097.9	11,776.5	321.4	97.3
Эд хогшил, урсгал засварын зардал	197,186.7	164,910.8	32,275.9	83.6
Багаж, техник, хэрэгсэл	140,000.0	108,120.0	31,880.0	77.2
Урсгал засвар	57,186.7	56,790.8	395.9	99.3
Томилолт, зочны зардал	41,791.7	34,339.9	7,451.8	82.2
Дотоод албан томилолт	41,791.7	34,339.9	7,451.8	82.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,028,660.9	4,864,360.2	164,300.7	96.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,705,612.1	4,551,738.2	153,873.9	96.7
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	118.8	118.8		100.0
Даатгалын үйлчилгээ	29,996.6	26,546.6	3,450.0	88.5
Тээврийн хэрэгслийн татвар	2,129.0	1,818.5	310.5	85.4
Тээврийн хэрэгслийн оношилгоо	477.7	404.0	73.7	84.6
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	49,500.0	43,959.3	5,540.7	88.8
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	240,826.7	239,774.7	1,052.0	99.6
Бараа үйлчилгээний бусад зардал	103,525.9	83,702.1	19,823.8	80.9
Бараа үйлчилгээний бусад зардал	25,539.9	25,508.0	31.9	99.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	77,986.0	58,194.1	19,791.9	74.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	177,388.1	176,968.0	420.1	99.8
Засгийн газрын урсгал шилжүүлэг	28,382.0	27,966.6	415.4	98.5
Засгийн газрын гадаад шилжүүлэг	28,382.0	27,966.6	415.4	98.5
Бусад урсгал шилжүүлэг	149,006.1	149,001.4	4.7	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	122,756.6	122,756.6		100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,249.5	26,244.8	4.7	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,214,759.7	9,966,521.6	248,238.1	97.6
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,214,759.7	9,958,691.3	256,068.4	97.5
Улсын төсвөөс санхүүжих	10,214,759.7	9,958,691.3	256,068.4	97.5
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		7.8	-7.8	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		7.4	-7.4	
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ		-	-	
Хандив тусламж /дотоод/		-	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	67.2	0.0		

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	672	672	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	32	32	100.0
Төсвийн байгууллага	32	32	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	320	320	100.0
Удирдах ажилтан	34	34	100.0
Гүйцэтгэх ажилтан	239	239	100.0
Гэрээт ажилтан	47	47	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	320	320	100.0
Ажлын албаны албан хаагч (АА)	266	266	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	100.0
Гэрээт ажилтан	47	47	100.0
Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	100.0

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		5,804,663.4
УРСГАЛ ЗАРДАЛ		5,804,663.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		5,625,211.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		439,580.0
Үндсэн цалин		159,982.4
Нэмэгдэл		47,822.4
Унаа хоолны хөнгөлөлт		7,797.4
Урамшуулал		15,238.4
Гэрээт ажлын хөлс		208,739.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		40,379.9
Тэтгэврийн даатгал		40,318.6
Тэтгэмжийн даатгал		15.3
ҮОМШӨ-ний даатгал		12.4
Ажилгүйдлийн даатгал		3.1
Эрүүл мэндийн даатгал		30.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		900.0
Байрны түрээс		900.0
Хангамж, бараа материалын зардал		477,986.5
Бичиг хэрэг		23,880.5
Тээвэр, шатахуун		242,660.3
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		13,250.2
Ном, хэвлэл		197,749.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		446.4
Нормативт зардал		4,846.0
Хоол, хүнс		4,846.0
Эд хогшил, урсгал засварын зардал		37,972.1
Багаж, техник, хэрэгсэл		29,579.9
Тавилга		5,892.3
Урсгал засвар		2,500.0
Томиллолт, зочны зардал		280,265.6
Гадаад албан томиллолт		28,954.7
Дотоод албан томиллолт		251,310.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4,014,598.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,955,156.7
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		59,441.9
Бараа үйлчилгээний бусад зардал		328,682.7
Бараа үйлчилгээний бусад зардал		67,690.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		260,992.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		179,452.0
Бусад урсгал шилжүүлэг		26,041.2
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		4,149.9
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		304.4
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		21,586.9
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		153,410.7
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		153,410.7
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		5,804,663.4
Нэмэлт санхүүжилтийн орлого		5,804,663.4
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1,208,664.0
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,131,159.9
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,242,469.5
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		222,370.0

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Д/д	№	Харьяа байгууллага	Аудитад хамрагдсан хэлбэр			Нийт зөрчил		Залруулсан алдаа		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Итгэл үзүүлсэн	Түүвэрт	Дүгнэлт Зөрчилгүй	Тоо	Дүн /мянган төгрөг/	Тоо	Дүн /мянган төгрөг/	Тоо	Дүн /мянган төгрөг/	Тоо	Дүн /мянган төгрөг/	Тоо	Дүн /мянган төгрөг/
A		1	2	3	4	9	10	11	12	13	14	15	16	17	18
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ															
1	1	Архангай аймаг дахь Статистикийн хэлтэс	1												
2	2	Баян-Өлгий аймаг дахь Статистикийн хэлтэс	1												
3	3	Баянхонгор аймаг дахь Статистикийн хэлтэс	1												
4	4	Дорноговь аймаг дахь Статистикийн хэлтэс	1												
5	5	Завхан аймаг дахь Статистикийн хэлтэс	1												
6	6	Дундговь аймаг дахь Статистикийн хэлтэс	1												
7	7	Говь-Алтай аймаг дахь Статистикийн хэлтэс			1	3	32,272.0	1	1,742.7	1	465.3	1	30,064.0		
8	8	Говьсүмбэр аймаг дахь Статистикийн хэлтэс			1	5	39,592.3	3	3,595.8					2	35,996.5
9	9	Дархан-Уул аймаг дахь Статистикийн хэлтэс			1	2	1,724.5	1	1,724.5					1	
10	10	Дорнод аймаг дахь Статистикийн хэлтэс			1	2	27,888.5					1	27,800.9	1	87.6
11	11	Орхон аймаг дахь Статистикийн хэлтэс			1	4	32,058.6	2	32,058.6					2	
12	12	Өвөрхангай аймаг дахь Статистикийн хэлтэс			1	2	28,721.9					1	5,383.9	1	23,338.0
13	13	Өмнөговь аймаг дахь Статистикийн хэлтэс			1	4	5,714.5	3	3,834.9			1	1,879.6		
14	14	Сүхбаатар аймаг дахь Статистикийн хэлтэс			1	0	-								
15	15	Сэлэнгэ аймаг дахь Статистикийн хэлтэс			1	2	8,920.2	1	8,125.0					1	795.2
16	16	Төв аймаг дахь Статистикийн хэлтэс			1	2	5,236.6	2	5,236.6						
17	17	Увс аймаг дахь Статистикийн хэлтэс			1	0	-								
18	18	Ховд аймаг дахь Статистикийн хэлтэс			1	2	1,304.7			1	186.0			1	1,118.7
19	19	Хөвсгөл аймаг дахь Статистикийн хэлтэс			1	0	-								
20	20	Хэнтий аймаг дахь Статистикийн хэлтэс			1	3	7,075.9	2	6,555.0					1	520.9
21	21	Нийслэлийн Статистикийн газар			1	7	69,144.0	6	29,091.0					1	40,053.0
22	22	Булган аймгийн статистикийн хэлтэс		1		-	-								
23	23	Үндэсний статистикийн хороо /аппарат/		1		2	20,800.0							2	20,800.0
		ДҮН	6	2	15	40	280,453.7	21	91,964.1	2	651.3	4	65,128.4	13	122,709.9
		НИЙТ ДҮН	6	2	15	40	280,453.7	21	91,964.1	2	651.3	4	65,128.4	13	122,709.9

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар тогтоосон төлбөрийн актын нэгтгэл

Д/д	Харьяа байгууллага	Төлбөрийн акт тогтоосон зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая.төг/	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Говь-Алтай аймаг дахь Статистикийн хэлтэс	Томилолтын зардал илүү олгосон, шатахууны зарцуулалтад норм стандартын дагуу тооцоо бодоогүй	0.5	Говь-Алтай аймаг дахь Статистикийн хэлтсийн дарга, Нягтлан бодогч	Д.Тунгалаг А.Банзрагч
2	Ховд аймгийн Статистикийн хэлтэс	Албан ажлынхаа автомашиныг тогтоосон километрээс хэтрүүлэн хэрэглэснээс 186.0 мянган төгрөгийн шатахуун илүү зарцуулсан.	0.2	Ховд аймаг дахь Статистикийн хэлтсийн дарга, Нягтлан бодогч	Д.Даваасамбуу Т.Анхбаяр
	ДҮН		0.7		

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар хүргүүлсэн албан шаардлагын нэгтгэл

Д/д	Харьяа байгууллага	Албан шаардлагын товч утга	Мөнгөн дүн /сая.төг/	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Өвөрхангай аймгийн статистикийн хэлтэс	Нэмэлт санхүүжилтийн данснаас маягт хэвлүүлэхдээ маягтыг материалын тайлангаар дамжуулалгүй шууд зарцуулсан.	5.4	Өвөрхангай аймгийн статистикийн хэлтсийн дарга Нягтлан бодогч	О.Түмэнжаргал Д.Чанцалдулам
2	Говь-Алтай аймгийн статистикийн хэлтэс	Тээвэр шатахууны зарцуулалтад худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, Хичээл практикийн зардлыг тооцоход нярвын тайланд орлогоор бүртгээгүй шууд зардлаар тайлагнасан, Хөрөнгийн тооллогыг НББ-тэй тулгахад бараа материалыг дутуу тоолсон.	30.0	Говь-Алтай аймаг дахь Статистикийн хэлтсийн дарга, Нягтлан бодогч	Д.Тунгалаг А.Банзрагч
3	Өмнөговь аймгийн статистикийн хэлтэс	Аудитаар ажиллагсадтай холбоотой өглөгтэй гарсан	1.9	Өмнөговь аймгийн статистикийн хэлтсийн дарга Нягтлан бодогч	С.Бямбабаатар А.Жамъянлхам
4	Дорнод аймгийн статистикийн хэлтэс	Тайлант хугацаанд 27.8 сая төгрөгийн худалдан авалтын Е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй	27.8	Дорнод аймгийн статистикийн хэлтсийн дарга	Д.Энхбаатар
	ДҮН		65.1		